



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 49

Номгон

Сумдын эргэлтийн эмийн сангийн үйл
ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах,
хөрөнгийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “ж”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 132 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор-Хайрхан фарм” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулагдсантай холбогдуулан сумдын эргэлтийн эмийн сангуудыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

2. Сумдын эргэлтийн эмийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан хавсралтад заагдсан дүнгээр хөрөнгийг “Баянхонгор-Хайрхан фарм” ОНӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Эргэлтийн эмийн сангуудын дуусгалтын баланс, шинээр байгуулагдсан үйлдвэрийн газрын эхлэлтийн балансыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргаж, хөрөнгийг ажлын хэсэг томилж хүлээн авч бүртгэхийг “Баянхонгор-Хайрхан фарм” ОНӨААТҮГ-ын дарга /С.Буянжаргал/-д даалгасугай.

4. Татан буугдсан, шинээр байгуулагдсан орон нутгийн өмчит байгууллагуудын хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, хэрэгжилтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА




Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0117361

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралт



**СУМДЫН ЭРГЭЛТИЙН ЭМИЙН САНГУУДЫН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ХӨРӨНГӨ	ӨР ТӨЛБӨР, ӨМЧ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	45 887 956,38	
2	Дансны авлага	16 272 922,58	
3	Татвар, НДШ-ийн авлага		
4	Бусад авлага	389 181,00	
5	Бараа материал	419 156 679,33	
6	Урьдчилж төлсөн зардал		
7	Бусад хангамжийн материал	4 723 720,40	
	Эргэлтийн хөрөнгийн дүн	486 430 459,69	
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	486 430 459,69	
8	Үндсэн хөрөнгө /цэвэр/	168 433 238,39	
9	Дуусаагүй барилга		
10	Бусад үндсэн хөрөнгө		
11	Биет бус хөрөнгө	5 092 594,80	
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	173 525 833,19	
	НИЙТ ХӨРӨНГӨ	659 956 292,88	
12	Дансны өглөг		14 410 785,53
13	Цалингийн өглөг		
14	НДШ-ийн өглөг		
15	Татвар, шимтгэлийн өглөг		
16	Богино хугацаат өр төлбөр		
	Богино хугацаат өр төлбөрийн дүн		14 410 785,53
17	Төрийн өмч		207 505 076,00
18	Хувийн өмч		69 549 651,46
19	Эздийн өмчийн бусад өмч		5 567 743,00
20	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		26 548 880,53
21	Хуримтлагдсан ашиг		148 939 411,30
22	Тайлангийн үеийн ашиг		187 434 745,06
	ӨМЧИЙН ДҮН		645 545 507,35
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ		659 956 292,88